ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Хэнтий аймгийн Цагдаагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2026/069/НА-СТА-ТШ3**

Чингис хот

2026 он


Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 2
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 4
**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 11
**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 12
**5. Аудитын тайлангийн хавсралт** ........ 13

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХөрөнгө | Засаг даргын нөөц хөрөнгө |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 374

танай ______ -ны № ______ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.ХАТАНБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Цагдаагийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд улсын төсвөөс 9,300,107.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 127,466.2 мянган төгрөг нийт 9,427,574.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн гүйцэтгэлээр 9,072,507.2 мянган төгрөгийг зарцуулж, 355,066.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс 247,174.9 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн дансанд 212,137.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн 92.6 хувь 196,473.5 мянган төгрөгийг зарцуулж 15.664.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлсэн “Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системд холбогдох дэд бүтцийн программ хангамж” төсөл арга хэмжээний хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар” Хэнтий аймгийн Жаргалтхаан, Хэрлэн суманд агшны хурд тодорхойлох цэг, Цэнхэрмандал, Хэрлэн суманд байнгын хяналтын цэг байгуулж, иж бүрэн тоног төхөөрөмж суурилуулсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 7 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 89.6 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 487,683,583.44 | 855,640,981.85 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 38,691,630.00 | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 38,691,630.00 | - |
| 3121 | Төгрөг | 38,691,630.00 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 38,691,630.00 | |
| 33 | АВЛАГА | 68,342,689.00 | 315,517,545.41 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | | 247,174,856.41 |
| 335 | Бусад авлага | 68,342,689.00 | 68,342,689.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 68,342,689.00 | 68,342,689.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 380,649,264.44 | 540,123,436.44 |
| 351 | Түүхий эд материал | 173,951,232.45 | 193,912,517.95 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 171,817,920.45 | 191,652,135.95 |
| 35130 | Эм боох материал | 2,133,312.00 | 2,260,382.00 |
| 354 | Хангамжийн материал | 141,198,061.99 | 273,760,794.49 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 17,221,637.00 | 21,575,359.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 37,945,088.36 | 38,120,845.86 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 9,912,195.00 | 128,361,398.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 18,286,700.00 | 13,584,100.00 |
| 35460 | Хүнсний материал | 5,257,250.00 | |
| 35470 | Бусад хангамжийн материал | 52,575,191.63 | 72,119,091.63 |
| 35600 | Мал амьтад | 65,499,970.00 | 72,450,124.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 7,382,429,391.19 | 7,858,756,818.61 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 7,382,429,391.19 | 7,858,756,818.61 |
| 392 | Биет хөрөнгө | 6,373,810,391.19 | 6,788,529,418.69 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 6,308,590,862.62 | 6,368,278,927.62 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,371,452,421.96) | (1,500,091,409.04) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 809,926,405.38 | 1,334,782,265.05 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (323,103,842.62) | (491,816,778.20) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 2,355,477,490.42 | 2,715,747,810.52 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,622,014,006.08) | (1,845,905,545.31) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 121,671,469.04 | 98,040,678.26 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (87,789,441.44) | (53,334,498.07) |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 56,538,109.00 | 56,538,109.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 252,740,183.00 | 257,350,183.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (126,774,416.17) | (151,060,324.14) |
| 393 | Биет бус хөрөнгө | 1,008,619,000.00 | 1,070,227,399.92 |
| 39301 | Програм хангамж | 3,100,000.00 | 67,288,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (900,000.00) | (3,479,600.08) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,006,419,000.00 | 1,006,419,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 7,870,112,974.63 | 8,714,397,800.46 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 55,991,034.00 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 55,991,034.00 | - |
| 413 | Өглөг | 55,991,034.00 | - |
| 4136 | Бусад өглөг | 55,991,034.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 55,991,034.00 | |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 7,814,121,940.63 | 8,714,397,800.46 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 7,814,121,940.63 | 8,714,397,800.46 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,785,692,062.39 | 2,785,692,062.39 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,785,692,062.39 | 2,785,692,062.39 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 3,402,280,294.60 | 4,302,556,154.43 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,402,280,294.60 | 3,458,271,328.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 844,284,825.83 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,626,149,583.64 | 1,626,149,583.64 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 7,870,112,974.63 | 8,714,397,800.46 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **9,242,324,094.82** | **10,625,641,478.58** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,821,768,281.12** | **1,360,571,078.58** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,821,768,281.12 | 1,360,571,078.58 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,821,768,281.12 | 1,360,571,078.58 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 122,591,440.00 | 127,466,225.01 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,699,176,841.12 | 1,233,104,853.57 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **7,420,555,813.70** | **9,265,070,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 7,043,840,300.00 | 9,052,932,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 7,043,840,300.00 | 9,052,932,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 376,715,513.70 | 212,137,500.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 156,896,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 119,032,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 100,787,513.70 | 212,137,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **8,228,279,466.70** | **9,723,478,929.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,227,119,466.70** | **9,723,478,929.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 7,919,534,768.10 | 8,619,903,936.98 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 6,082,506,574.74 | 6,889,030,344.12 |
| 210101 | Үндсэн цалин | 3,675,120,482.58 | 3,645,634,008.13 |
| 210102 | Нэмэгдэл | 2,198,921,182.63 | 2,409,342,389.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 103,197,242.11 | 238,117,039.22 |
| 210104 | Урамшуулал | 105,267,667.42 | 86,422,980.20 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 509,513,926.65 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 139,511,551.98 | 159,626,667.68 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 12,755,776.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 603,122.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 1,478,087.71 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 525,209.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 139,511,551.98 | 144,264,472.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 240,772,030.04 | 244,064,672.10 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 115,082,574.04 | 132,810,330.10 |
| 210302 | Түлш, халаалт | 104,998,650.00 | 104,856,618.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 20,690,806.00 | 6,397,724.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 369,619,905.50 | 334,698,376.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 50,634,065.50 | 61,553,660.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 226,111,090.00 | 250,050,922.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 39,659,995.50 | 13,081,102.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,640,637.50 | 10,012,692.50 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 43,574,117.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 117,058,553.00 | 70,647,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,222,058.00 | 2,355,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 113,836,495.00 | 68,292,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 144,462,195.00 | 106,091,650.00 |
| 210602 | Тавилга | 175,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 144,287,195.00 | 106,091,650.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 63,723,700.00 | 48,490,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 63,723,700.00 | 48,490,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,621,235.84 | 9,181,114.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,336,567.00 | 2,960,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 679,993.84 | 2,905,941.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,117,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 172,375.00 | 1,971,335.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 256,300.00 | 226,838.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 744,259,022.00 | 758,073,212.58 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,458,200.00 | 60,152,197.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,597,252.50 | 1,620,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 685,203,569.50 | 696,301,015.08 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 307,584,698.60 | 1,103,574,992.11 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 291,284,739.28 | 980,019,045.51 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 637,647,557.41 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 183,615,195.80 | 312,035,088.10 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 107,669,543.48 | 30,336,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 16,299,959.32 | 123,555,946.60 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,356,563.79 | 107,891,921.60 |
| 213304 | Хөрөнгийн | 2,943,395.53 | 15,664,025.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,160,000.00** | **0.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,160,000.00 | 0.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,160,000.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,014,044,628.12** | **902,162,549.49** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 0.00 | 57,877,724.07 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 56,479,124.07 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 1,398,600.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 0.00 | -57,877,724.07 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,014,044,628.12** | **844,284,825.42** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **7,563,283,153.70** | **9,442,965,975.01** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **142,727,340.00** | **177,895,575.01** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 142,727,340.00 | 177,895,575.01 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 142,727,340.00 | 177,895,575.01 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 122,591,440.00 | 127,466,225.01 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,135,900.00 | 50,429,350.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **7,420,555,813.70** | **9,265,070,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 7,043,840,300.00 | 9,052,932,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 7,043,840,300.00 | 9,052,932,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 376,715,513.70 | 212,137,500.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 156,896,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 119,032,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 100,787,513.70 | 212,137,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **7,544,408,053.70** | **9,418,585,305.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,544,408,053.70** | **9,418,585,305.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **7,236,985,355.10** | **8,067,835,456.90** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 6,102,642,474.74 | 6,945,588,074.82 |
| 210101 | Үндсэн цалин | 3,554,466,799.65 | 3,907,072,992.42 |
| 210102 | Нэмэгдэл | 2,339,710,765.56 | 2,397,824,356.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 103,197,242.11 | 237,288,238.29 |
| 210104 | Урамшуулал | 105,267,667.42 | 86,422,980.20 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 316,979,507.31 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 139,511,551.98 | 153,498,286.98 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 8,997,206.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 1,031,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 824,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 206,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 139,511,551.98 | 142,438,880.83 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 245,558,325.04 | 258,545,797.10 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 115,082,574.04 | 132,810,330.10 |
| 210302 | Түлш, халаалт | 109,784,945.00 | 119,337,743.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 20,690,806.00 | 6,397,724.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 334,365,300.50 | 430,943,552.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 56,966,235.00 | 62,729,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 228,813,240.00 | 347,639,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 39,828,745.50 | 13,081,102.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 400,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,357,080.00 | 7,493,650.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 112,831,017.00 | 65,516,820.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,465,900.00 | 2,482,070.00 |
| 210502 | Хоол, хүнс | 110,183,617.00 | 63,034,750.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 181,500.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 116,454,430.00 | 108,581,350.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 775,000.00 | 6,535,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 142,500.00 | 166,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 115,536,930.00 | 101,879,050.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 63,522,700.00 | 48,490,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 63,522,700.00 | 48,490,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 27,015,155.84 | 9,540,776.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,996,787.00 | 3,546,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 669,993.84 | 2,905,941.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,117,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 172,375.00 | 1,971,335.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 95,084,400.00 | 47,129,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 93,689,400.00 | 45,509,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,395,000.00 | 1,620,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **307,422,698.60** | **1,350,749,848.11** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 291,122,739.28 | 980,019,045.11 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 637,647,557.41 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 183,615,195.80 | 312,035,087.70 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 107,507,543.48 | 30,336,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 16,299,959.32 | 370,730,803.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,356,563.79 | 298,339,078.00 |
| 213304 | Хөрөнгийн | 2,943,395.53 | 72,391,725.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **18,875,100.00** | **24,380,670.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **28,541,200.00** | **63,072,300.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **28,541,200.00** | **63,072,300.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 28,541,200.00 | 63,072,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 28,541,200.00 | 63,072,300.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-28,541,200.00** | **-63,072,300.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -9,666,100.00 | -38,691,630.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 48,357,730.00 | 38,691,630.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 38,691,630.00 | 0.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,785,692,062.39 | 1,626,149,583.64 | 3,402,280,294.60 | | 7,814,121,940.63 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,785,692,062.39** | **1,626,149,583.64** | **3,402,280,294.60** | **0.00** | 7,814,121,940.63 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,785,692,062.39** | **1,626,149,583.64** | **3,402,280,294.60** | **0.00** | 7,814,121,940.63 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,785,692,062.39** | **1,626,149,583.64** | **3,402,280,294.60** | **0.00** | 7,814,121,940.63 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 55,991,034.00 | | 55,991,034.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,785,692,062.39** | **1,626,149,583.64** | **3,458,271,328.60** | **0.00** | 7,870,112,974.63 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 844,284,825.83 | | 844,284,825.83 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,785,692,062.39** | **1,626,149,583.64** | **4,302,556,154.43** | **0.00** | 8,714,397,800.46 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 9,169,333,000.00 | 8,882,060,047.01 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 9,169,333,000.00 | 8,882,060,047.01 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 8,031,969,000.00 | 7,924,077,401.90 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 6,942,253,600.00 | 6,940,253,594.82 |
| 210101 | Үндсэн цалин | 3,555,422,000.00 | 3,901,738,512.42 |
| 210102 | Нэмэгдэл | 2,568,553,000.00 | 2,397,824,356.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 439,223,500.00 | 237,288,238.29 |
| 210104 | Урамшуулал | 281,442,300.00 | 86,422,980.20 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 97,612,800.00 | 316,979,507.31 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 159,551,300.00 | 153,498,286.98 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,764,500.00 | 8,997,206.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 148,724,600.00 | 142,438,880.83 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 242,614,600.00 | 238,552,322.10 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 115,467,200.00 | 132,810,330.10 |
| 210302 | Түлш, халаалт | 103,595,400.00 | 99,344,268.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 23,552,000.00 | 6,397,724.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 454,299,500.00 | 400,332,152.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 48,656,600.00 | 47,474,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 381,039,600.00 | 332,283,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 17,218,800.00 | 13,081,102.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 398,600.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,985,900.00 | 7,493,650.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 33,634,500.00 | 29,974,770.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 747,800.00 | 262,070.00 |
| 210502 | Хоол, хүнс | 29,899,300.00 | 29,712,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,987,400.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 103,744,900.00 | 101,814,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,328,800.00 | 13,265,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,991,600.00 | 166,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 88,424,500.00 | 88,382,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 64,073,200.00 | 48,490,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 64,073,200.00 | 48,490,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,877,400.00 | 9,540,776.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,535,700.00 | 2,905,941.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 210,500.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,431,000.00 | 1,117,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,153,700.00 | 1,971,335.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,920,000.00 | 1,620,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,920,000.00 | 1,620,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,137,364,000.00 | 957,982,645.11 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,137,364,000.00 | 957,982,645.11 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 731,349,000.00 | 637,647,557.41 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 397,715,000.00 | 312,035,087.70 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 9,169,333,000.00 | 8,882,060,047.01 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 9,052,933,000.00 | 8,754,593,822.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 9,052,933,000.00 | 8,754,593,822.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 116,400,000.00 | 127,466,225.01 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 116,400,000.00 | 127,466,225.01 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,134,977.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,134,977.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,134,977.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,969,977.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,969,977.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 165,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 165,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,134,977.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,134,977.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 784,977.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,350,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**Аудитын явцад 891,868.4 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:**

*Залруулсан алдаа:*

- Баян-Овоо сумын 885,488.4 мянган төгрөгийн үнэлгээтэй Цагдаагийн хэсгийн байрыг дээд газрын шийдвэргүй бүртгэснийг бүртгэлээс хасч залруулав.
- Түлш, шатах тослох материалын 6,380.0 мянган төгрөгийн урамшууллын орлогыг бүртгэлд тусгав.

**Аудитаар илэрсэн 2,782.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.**

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

1. Цалингаас суутгасан 2,782.2 мянган сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчийн төлөх шимтгэлийн зардлаас төлж батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын “2101-цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд энэ англалд хамаарна”, 2102- ажил олгогчоос тайлант хугацаанд Нийгмийн даатгалын тухай болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан хэмжээгээр үндсэн болон нэмэгдэл цалин, түүнтэй адилтгах орлогоос албан журмаар төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тооцож энэ ангилалд бүртгэнэ.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Шилэн дансны нэгдсэн системд батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, дараа жилийн төсвийн төслийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, худалдан авалтыг дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т.”таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

***Санхүүгийн аудитын асуудлаар илрүүлсэн 2,782.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.***

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулагдаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шийдвэргүй үндсэн хөрөнгө орлого авсан. | 1 | 885,488.4 | - | - | 1 | 885,488.4 | 1 | 885,488.4 | - | - | - | - |
| Орлого бүртгээгүй. | 1 | 6,380.0 | 1 | 6,380.0 | - | - | 1 | 6,380.0 | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **891,868.4** | **1** | **6,380.0** | 1 | 885,488.4 | **2** | **891,868.4** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эдийн засгийн ангилал зөрүүлсэн | 1 | 2,782.2 | | | 1 | 2,782.2 | | | | | | |
| **Дүн** | **1** | **2,782.2** | **-** | **-** | **1** | **2,782.2** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Мэдээлэлгүй | 1 | - | | | 1 | - | | |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **-** | **-** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** | | |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 Дугаар 139- А2370448 Чингис хот
ХЭА- 2026/069/НА-СТА-ТШ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Цагдаагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингаас суутгасан 2,782,211.00 (хоёр сая долоон зуун наян хоёр мянга хоёр зуун арван нэг) төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчийн төлөх шимтгэлийн зардлаас төлж батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчиж зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь *Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын “2101-цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд энэ ангилалд хамаарна”, 2102- ажил олгогчоос тайлант хугацаанд Нийгмийн даатгалын тухай болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан хэмжээгээр үндсэн болон нэмэгдэл цалин, түүнтэй адилтгах орлогоос албан журмаар төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тооцож энэ ангилалд бүртгэнэ.”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бус зарцуулсан” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалт бус зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг нягтлан бодогч Ц.Цэрэнпүрэвт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.АРИУНАА

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 Дугаар 140-А2370448 Чингис хот

ХЭА-2026/069/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Цагдаагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн системд батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, дараа жилийн төсвийн төслийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, худалдан авалтыг дутуу мэдээлсэн байна.

Энэ нь *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.*

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлдэггүй, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга, цагдаагийн хурандаа Д.Хатанбаатар, нягтлан бодогч Ц.Цэрэнпүрэвт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.АРИУНАА